



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/822

Ховд

Төсөвт зохицуулалт хийх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 42 дугаар зүйлийн 42.2.1, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 15 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ Ховд Жаргалант” ТҮК Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас ирүүлсэн хүсэлт, Ковид-19 цар тахалын үеийн санхүүжилтийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн дутуугаас үүссэн ажилчдын цалингийн өрийг барагдуулахаар байгаль хамгаалах сан болон замын сангаас хөтөлбөр хооронд хэрэгжүүлэх 23230.0 мянган төгрөгийн зохицуулалтыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хөтөлбөр хооронд зохицуулалт хийсэн 23230.0 мянган төгрөг /хорин гурван сая хоёр зуун гучин мянган/-ийг “Шинэ Ховд Жаргалант” ТҮК Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто болон явган хүний замын цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан гүйцэтгэж буй ажилчдын цалингийн өрийг барагдуулахаар зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Зохицуулалт хийсэн төсвийг зориулалтын дагуу зарцуулан өр, авлагыг барагдуулж ажиллахыг “Шинэ Ховд Жаргалант” ТҮК Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга /Д.Бумцэнд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 21-ний өдрийн  
А/822 дугаар захирамжийн хавсралт



**“ШИНЭ ХОВД ЖАРГАЛАНТ” ТҮК ОНӨААТҮГ-ЫН  
ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭГ ХАРИУЦСАН АЖИЛЧДЫН  
ЦАЛИНД ЗАРЦУУЛАХ САНХҮҮЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

		2021 оны батлагдсан хөтөлбөр		Зарцуулагдаагүй үлдэгдэл дүн /төгрөг/	Зохицуулан зарцуулах хөтөлбөрийн нэр	Дүн /төгрөг/
	Дугаар	Нэр				
1.	Байгаль хамгаалах сан	2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль орчны зорилтуудыг хэрэгжүүлэх зардал /төсөв 55500.0 гэрээ байгуулсан 43500.0 /	12000000.00	“Шинэ Ховд Жаргалант” ТҮК ОНӨААТҮГ-ЫН ажилчдын цалинд	12000000.00
		Дүн		12000000.00		12000000.00
2	Замын сан	1.3.	Төв 4 замын уулзвараас Талын буудлын 3 замын уулзвар хүртэлх замын 2 талын талбайн тохижилт /Жаргалант сум/ /Төсөв 80000.0 Гэрээ 72000.0/	8000000.00	“Шинэ Ховд Жаргалант” ТҮК ОНӨААТҮГ-ЫН ажилчдын цалинд	8000000.00
		2.2.	Гүүр барих /Мянгад сум, Боомын ам/ Төсөв 70000.0 Гэрээ 68000.0	2000000.00		2000000.00
		2.5	Замын тэмдэг тэмдэглэгээ /Жаргалант сум/ /Төсөв 80000.0 Гэрээ 76000.0/	1230000.00		1230000.00
		Дүн		11230000.00		
Нийт дүн						23230000.00